



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/383

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний 0-24 насны хүүхэд, залуучуудын боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг судлан илрүүлэхэд чиглэсэн “Монголын боловсрол-өнөөдөр” үндэсний хэмжээний суурь судалгааг орон нутагт зохисон байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Ганзориг (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Ч.Дашбаяр (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Б.Базардамбуу (Статистикийн хэлтсийн дарга)

П.Галсандорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Мөнхсоёл (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

2. Судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хүрээнд дээрх судалгааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН